

**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<p>Эцэг/эхийн нэр: Чимэд Ургийн овог: Хайртынхан Нэр: Отгонсүрэн Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1978 Төрсөн газар: Улаанбаатар хот Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг</p>
1.2	<p>Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>Тийм</p>
1.3	<p>Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/</p> <p>Үгүй</p>
1.4	<p>Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу?</p> <p>Үгүй</p>
1.5	<p>Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу?</p> <p>Үгүй</p>
1.6	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу?</p> <p>Үгүй</p>
1.7	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу?</p> <p>Үгүй</p>
1.8	<p>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу?</p> <p>Үгүй</p>

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Чимэдийн Отгонсүрэн би Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь заалтыг үндэслэн Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвших хүсэлтээ илэрхийлж байна.</p> <p>Хуульчаас мэргэжлээс гадна эзэмшсэн нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн мэдлэгийнхээ хүрээнд шүүхийн төсөв, хангамжийн тал дээр санал, санаачлага гарган ажиллах болно.</p>
-----	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Тухайлбал, шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг үндэслэлтэй төлөвлөж, сайтар боловсруулан, төсвийн төсөөллийг мэргэжлийн төвшинд бэлтгэн танилцуулах, батлуулахад биечлэн оролцоно. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Дүүргийн эрүү, иргэний анхан шатны шүүхүүдийн байр хүрэлцээ муу, шүүх хуралдааны танхим хүлээгддэг, доторх агааржуулалт, орчин, ариун цэврийн өрөө хангалтгүй байгаагаас шүүгч, шүүхийн ажилтнууд, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд тав тухгүй байсаар байна. Иймд хөрөнгө оруулалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, бүтээн байгуулалтын ажлыг шуурхайлах тал дээр судалгаа тооцоо гарган, санаачлагатай ажиллаж, хамтын зарчмаар буюу Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

- Монгол Улсын шүүхийн шийдвэр хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн, зөрчигдсөн эрхийг нь сэргээсэн, гагцхүү хуульд захирагдсан, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүх хурдан шуурхай шийдвэр гаргадаг болоход бодит хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд хурдан, чирэгдэлгүй явуулахад анхаарах, 100% цахим хэлбэрээр чөлөөтэй шүүх хуралдааныг явуулдаг болгоход анхаарч ажиллана.

- Шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх нь шүүгч, шүүхийн ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдасгах, хэргийн шийдвэрийг хурдан гаргаж оролцогчдод гардуулах, иргэдэд нээлттэй байх зэрэг ач холбогдолтой гэж үзэж байна.

“Цахим шүүх 2.0” системийн шинэчлэлийн хүрээнд хиймэл оюуны шийдлүүдийг үе шаттай нэвтрүүлэх замаар төрийн бодлого, яам, хэрэгжүүлэгч газруудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцож ажиллана.

Үүний ач холбогдол нь шүүхийн шийдвэрийг цахим системд байршуулахдаа хэргийн оролцогчдын хувийн мэдээллийг AI ашиглан автоматаар таньж, нууцлах нь шүүхийн туслах ажилтаны гар ажиллагааг хөнгөвчилнө. Мөн шүүх хуралдааны явцын дуу хураагуурын бичлэгийг хиймэл оюунаар шууд хөрвүүлэн, хуралдааны тэмдэглэл алдаа мадаггүй, хурдан бичигдэх давуу талтай болно.

Хэргийн хөдөлгөөний удирдлагад хиймэл оюуныг ашигласнаар нэхэмжлэл, хэргийн материалыг ангилах, мета өгөгдөл үүсгэх, шүүх хуралдааны товыг системээс ухаалгаар хуваарилах ажиллагааг хийдэг болно.

Иргэдэд зориулсан цахим үйлчилгээ буюу ухаалаг чатботыг ашигладаг болвол иргэд нэхэмжлэл гаргах, гомдол, өргөдөл бичихдээ юуг анхаарах, улсын тэмдэгтийн хураамж төлөх, шүүхийн харьяалал тогтоох зэрэг анхан шатны зааварчилгааг өгөх туслахтай болно. Харин шүүхийн шаардсанаар шүүхэд гарган өгч буй нотлох баримт, бичиг баримтаа бэлтгэхдээ хиймэл оюун ухаан ашигласан эсэхээ албан ёсоор мэдүүлж, баталгаажуулах үүрэг хүлээх, өмгөөлөгч болон иргэд хэргийн материал, тайлбараа бэлдэхдээ AI ашиглаж болох ч, AI-ийн гаргасан аливаа алдаа, худал мэдээллийг шүүхийн өмнө өөрөө бүрэн хариуцдаг байх үүргийг хүлээлгэх зэрэг зохицуулалтыг хийх шаардлагатай.

Одоо үед хууль, эрх зүйн судалгаа, дүн шинжилгээ хийхэд хиймэл оюун ухааныг зайлшгүй ашигладаг болсон. Энэ нь шүүгч, хуульчдад тухайн хэрэгтэй ижил төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэж байсан шүүхийн шийдвэр, жишгийг дата баазаас хормын дотор шүүх өгдөг байх, олон хавтас хэргийн материал, хуулийн заалтуудыг нэгтгэн дүгнэх, зөрүүтэй байдлыг илрүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

<p>Гэхдээ эрүү, иргэний хэрэг дээр хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ эрс ялгаа заагтай бодлого баримтлах нь зүйтэй. Тухайлбал шүүгчийн өмнөөс эцсийн шийдвэр гаргах, ял оногдуулах эсхүл шүүхийн шийдвэрийг урьдчилан таамаглах үйлдлүүдийг хязгаарлаж, хориглох, мөн шүүхийн системийн аюулгүй байдал, хэргийн нууц материал гадагш алдагдахаас сэргийлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай гэж үздэг.</p> <p>Эрүүгийн хэрэгт яллах, цагаатгах, ял оноох нь зөвхөн шүүгчийн мэдлэг, ёс зүй, мэргэжлийн удирдлага дор явагдах ёстой гэсэн хатуу зарчмыг баримтална.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд ёс зүйтэй, хариуцлагатай ажиллаж Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан мэргэжлийн үйл ажиллагааг явуулахад анхаарч ажиллана.</p>

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. <p>1. Хууль, эрх зүйн газрын дарга, Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК. 2025 оны 1 дүгээр сарын 15-наас 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хооронд ажилласан. Хаяг: Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа, Гүйцэтгэх захирал Б.Отгонсүх office@ncac.mn, Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тушаал шийдвэр, гэрээ хэлцэл, эрх зүйн баримт бичгийг салбарын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, батлуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн мэргэжил арга зүйгээр хангах, компанийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллах. Хамтран ажиллаж байсан: Гүйцэтгэх захирал Б.Отгонсүх [redacted] Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Рэнцэнбямба [redacted] Санхүүгийн удирдлагын газрын дарга Г.Өлзийбүрэн [redacted] Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Ш.Янжиндулам [redacted] Гэрээний бүртгэл, хяналтын хэлтсийн дарга М.Эрдэнэсайхан [redacted] Хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Чүлтэм [redacted]</p> <p>2. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч. 2023 оны 03 дугаар сарын 13-наас одоог хүртэл.</p>

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол, Г.Чагдаржавын гудамж 32/2, Сав плаза 18-1804 тоот, 17-1702 тоот. Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров. info@umquulul.mn

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Хүний эрхийг хамгаалах, иргэдэд мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, шударга ёсыг эрхэмлэх, өмгөөлөгчийн мэргэжлийн хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах.

Хамтран ажиллаж байсан:

Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч асан, хуульч, өмгөөлөгч Б.Оюу-Эрдэнэ [REDACTED]

Хуульч, өмгөөлөгч, хууль зүйн ухааны доктор, дэд проф Я.Батханд [REDACTED]

Хуульч, өмгөөлөгч Э.Баярбаатар [REDACTED]

Хуульч, өмгөөлөгч Б.Сарнай [REDACTED]

Хууль, өмгөөлөгч Г.Оюунцэцэг [REDACTED]

3. Хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газар.

2014 оны 03 дугаар сарын 05-наас 2019 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд Мэдээлэл, дүн шинжилгээ, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтэст, 2019 оны 12 дугаар сарын 03-наас 2023 оны 02 дугаар сарын 16-ны хооронд Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтэст тус тус ажилласан.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж.

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурор Ц.Ариунболд. mpro@prosecutor.mn

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг нэр мөр хэрэглэх, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хараат бус, бие даасан, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллах.

Хамтран ажиллаж байсан:

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурор асан Б.Бат-Орших [REDACTED]

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч асан Ж.Ариунаа [REDACTED]

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч асан А.Энхжаргал [REDACTED]

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч асан А.Цэрэнсодном [REDACTED]

Сүхбаатар дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Т.Оргил-Очир [REDACTED]

Тээврийн прокурорын газрын хяналтын прокурор Т.Амарзаяа [REDACTED]

3.2 Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил

Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.

	<p>1. 2010 оны 7 дугаар сарын 23-наас 2014 оны 3 дугаар сарын 05-ны хооронд Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газарт Ахлах шинжээч-нягтлан бодогч. Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан [REDACTED] Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан хяналтын прокурор, доктор, проф Г.Ууганболор [REDACTED] Хяналтын прокурор Р.Энх-Оюун [REDACTED] Нягтлан бодогч Х.Саранцэцэг [REDACTED] Нярав Ц.Тогтохбаяр [REDACTED] Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18, Улсын Ерөнхий прокурорын газар. [REDACTED] gpo@prosecutor.mn</p> <p>2. 2002 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2010 оны 7 дугаар сарын 20-ны хооронд [REDACTED] [REDACTED] Албаны дарга Т.Батцэнгэл Ерөнхий нягтлан бодогч Ц.Мэрэгшир [REDACTED] Ахлах нягтлан бодогч Л.Онон [REDACTED] Хангамжийн менежер И.Наранхүү [REDACTED] Инженер Л.Дамба [REDACTED] Хаяг: Баянгол дүүрэг, [REDACTED] ubtz@ubtz.mn</p>
3.3	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>1. 2014 оны 3 дугаар сарын 05-наас 2023 оны 2 дугаар сарын 16-ны хооронд Монголын Прокуроруудын холбооны гишүүн, прокурор. 2019-2023 онд Монголын Прокуроруудын холбооны Хяналтын зөвлөлийн гишүүн. 2023 оны 2 дугаар сард прокурорын ажлаас сайн дураар чөлөөлөгдсөн тул МПХ-ны гишүүнчлэлийг дуусгавар болгосон.</p> <p>2. Улсын Дээд шүүхээс 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг олгосон. 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор томилогдсон тул өмгөөлөгчийн эрхийг түр түдгэлзүүлсэн. 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс өмгөөлөгчийн эрхийг сэргээсэн. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч.</p> <p>3. 2012 оны 9 дүгээр сарын 19-нөөс одоог хүртэл Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч.</p> <p>4. 2011 оноос одоог хүртэл Монголын Мэргэшсэн Нягтлан бодогчдын институтын гишүүн, Хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч.</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

4.1	<p>Хууль зүйн өндөр мэргэшил Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн</p>
-----	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

талаар дараах мэдээллийг заавал бичнэ:

- үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;
- үйл ажиллагааны гол агуулга;
- үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;
- үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;
- тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;
- хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.

Нэг. Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор 2014.03.05-наас 2019.04.24, 2019.12.02-ноос 2023.02.16-ны хооронд нийтдээ 8 жил 5 сарын хугацаанд ажиллахдаа хуулийг нэг мөр хэрэглэх, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, хараат бус, бие даасан, ил тод, нээлттэй байх зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан ажилласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн, прокурорын үндсэн 4 хяналтын чиглэлээр ажиллажээ. Үүнд:

Мэдээлэл дүн шинжилгээ, бодлого төлөвлөлтийн чиглэлээр: Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтын ажлын чиглэлээр судалгаа хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж прокуроруудад мэдээлэх, түүний мөрөөр зохиох ажлын талаар санал боловсруулан нэгжийн удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээ авч ажилласан. Мөн хугацаатай үүрэг даалгавар, байгууллагын мэдээ тайланг хугацаанд нь сар, улирал, жилээр нь үнэн зөв гаргаж, албан хэрэг хөтлөлтийн шаардлагад нийцүүлэн тайлагнасан.

Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр: Эрүүгийн хууль тогтоомжид заасан харьяаллын дагуу Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн Ерөнхий газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хар тамхитай тэмцэх газар, Хүрээлэн буй орчны гэмт хэрэгтэй тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллаж, төрийн нэрийн өмнөөс шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг шүүхэд нотлох үүргийг хүлээн улсын яллагчаар шүүх хуралдаанд оролцож, албан тушаалын болон ээдрээ төвөгтэй эдийн засгийн гэмт хэргүүдийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. Тухайлбал, “Жи тайм”-ын гэх тодотголтой олны анхаарал татсан 11300 гаруй хохирогч, 980 гаруй иргэний хариуцагчтай, 600 орчим хавтас залилангийн гэмт хэргийг, мөн 7,5 кг алт хууль бусаар хил нэвтрүүлсэн гэмт хэргийг, албан тушаалтны холбогдсон хар тамхины гэмт хэрэг зэрэг олны анхаарал татсан хэргүүд дээр ажилласан. (Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn>)

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиглэлээр: Ял эдлүүлэх ажиллагаа Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын гэрээгээр

тогтоосон стандарт, шаардлага болон Монгол Улсын хуульд заасан нөхцөл, дэглэмд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих,

- ялын хүмүүжүүлэх зорилгыг хангах үүднээс хоригдлын сургалт, хүмүүжлийн болон нийгэмшүүлэх ажилд хяналт тавьж, бусдад учруулсан хохирлоо барагдуулсан, хөдөлмөр эрхэлж олсон орлогоос нэн тэргүүд хохирлоо төлсөн хоригдлыг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулахаар дүгнэлт бичиж шүүхээр шийдвэрлүүлэх,

- ял эдлүүлэх, цагдан хорих, баривчлах шийдвэр биелүүлэх ажиллагааны явцад хууль зөрчсөн зөрчлийг арилгуулахаар прокурорын шаардлага бичих зэрэг арга хэмжээ авч ажилласан.

2021 онд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа болон хоригдлын ял эдлэлтийн байдалд хяналт тавихдаа хоригдлуудын ахуй нөхцөл, харуул хамгаалалт, сургалт нийгэмшүүлэх ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн нөхцөл болон сахилга, урамшууллын байдал, мөн эмнэлэгт хэвтсэн хоригдлуудын эмчилгээ үйлчилгээ, үйл ажиллагаатай сар бүр танилцаж, шалгах, танилцах ажиллагаагаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг тухай бүр авсан.

Үр дүн, жишээ: Шалгалтаар илэрсэн томоохон зөрчил, авсан арга хэмжээний талаар дурдвал, 401 дүгээр хаалттай хорих ангид хууль зөрчин хоригдлуудыг хөдөлмөрлүүлж байсан “Уран дарханы сургалтын төв”-ийн үйл ажиллагааг таслан зогсоож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт удаа дараа прокурорын шаардлага хүргүүлсний дүнд уг сургалтанд хамрагдаж байсан гэх хаалттай дэглэмийн 8, нээлттэй дэглэмийн 2 хоригдлыг зохих дэглэм, зэрэглэлийн газарт нь хуваарилуулан ял эдлүүлсэн.

Шүүхэд төрийг төлөөлөх хяналтын чиглэлээр: Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг шүүхээр сэргээлгэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхэд анхаарч ажилласан. Тухайлбал, 2022 онд Улсын Ерөнхий прокурорын газраас зохион байгуулсан “Дүгнэлт-Мэтгэлцээн” нэгдсэн арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд:

- шүүхээс шүүх хуралдааны бичлэгийг авч танилцах болон зарим прокурорын шүүх хуралдаанд биечлэн суух байдлаар нийт 22 прокурорын яллах, мэтгэлцэх ур чадварт дүн шинжилгээ хийж, ажлын арга барил, туршлага, онолын мэдлэгийг дүгнэж, цаашид анхаарах асуудлын талаар тус бүрд нь зориулсан “Зөвлөмж” гарган өгч, гаргасан алдаа дутагдлыг нь анхааруулж, тайлбарлаж өгсөн.

- шүүхийн шийдвэртэй танилцсан тэмдэглэлд хийсэн хууль зүйн дүгнэлтэд дүн шинжилгээ хийхэд шаардлага хангасан тэмдэглэл байгаагүй учраас жишиг гэж үзэхүйц тэмдэглэл ямар байвал зохилтой болохыг прокурор нэг бүрд хийж өгөх зэргээр прокуроруудын мэтгэлцэх, яллах ур чадварын суурь түвшинг тогтоож, прокурор бүртэй хяналтын ажлын чиглэлээр хамтран ажилласан. Үр дүн, жишээ: Байгууллагын хэмжээнд Дүгнэлт-Мэтгэлцээн нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажилласан бөгөөд улсын хэмжээнд Шүүхэд төрийг төлөөлөх шилдэг манлай прокуророор хэлтсийн дарга Х.Батчимэг, Шилдэг улсын яллагчаар хяналтын прокурор Г.Эрдэнэ нар тус тус шалгарсан.

Мөн улсын яллагчийн эсэргүүцлийг хууль зүйн үндэслэлтэй бичүүлэх зорилгоор давах, хяналтын шатны шүүхэд бичсэн 90 эсэргүүцлээс 53 эсэргүүцлийн төслийг хянаж, зөвлөсөн байна. 2022 онд шүүхээс нийтдээ 700 гаруй шүүхийн шийдвэр хүлээн авснаас, 206 шийтгэх тогтоол, 115 магадлал, 48 захирамжид хууль зүйн дүгнэлт хийж улсын яллагч, прокуроруудад танилцуулсан байна.

Хийсэн шалгалт, судалгааны талаар:

1. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт (2002 оны Эрүүгийн хуулийн 202, 203, 204, 205, 206, 207, 208, 209, 210, 211, 212, 213, 214, 214¹ дүгээр зүйл, 2015 оны Эрүүгийн хуулийн 24.1, 24.2, 24.3, 24.4, 24.5, 24.6, 24.7, 24.8, 24.9 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хүрээнд) хохирол нөхөн төлүүлсэн байдал, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрийг улсын яллагчийн дүгнэлттэй харьцуулан судлах судалгааг 2019, 2020, 2021 оны байдлаар Нийслэл, дүүргийн прокурорын газрын хэмжээнд судалж, судалгааны дүнг Нийслэлийн Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн хуралдаанд танилцуулж, цаашид дээрх гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл боловсруулан, Нийслэлийн прокурорын газрын ХБМБАХТХ-ийн прокуроруудад болон Дүүргийн прокурорын газруудад хүргүүлсэн.

2. Нийслэлийн прокурорын газраас зохион байгуулсан “Хүүхдийн эрх” нэгдсэн аяны хүрээнд хүүхдийн эсрэг болон хүүхэд хохирсон гэмт хэргийн шийдвэрлэлтийг 2021 он, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар судалж, дүн шинжилгээ хийсэн.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйл “Хүчиндэх”, 12.2 дугаар зүйл “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”, 12.5 дугаар зүйл “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ял, улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын дүгнэлтийг 2021 оны байдлаар харьцуулан судалсан.

4. Тодорхой төрлийн буюу Авлига, албан тушаалын гэмт хэрэг, Мөнгө угаах, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн судалгааг 2021, 2022 оны байдлаар гаргаж, Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлсэн.

5. Тус прокурорын газрын хэмжээнд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн судалгааг 2020, 2021, 2022 оны байдлаар гаргаж, эрүүгийн хариуцлага, хохирол төлбөр зэргийг судалж, танилцуулсан байна.

Хоёр. Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-д 2025.01.15-наас 2025.08.22-ны хооронд Хууль, эрх зүйн газрын даргаар ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2024.11.27-ны өдрийн 193 дугаар тогтоолоор Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх “Иргэний нисэхийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулж, Зам, тээврийн сайдын 2024.12.27-ны өдрийн А/290 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталсанаар шинээр байгуулагдсан төрийн өмчит компанийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх “Хөдөлмөрийн дотоод журам, Цалин хөлсний журам, Гэрээ

байгуулах, бүртгэх журам батлах тухай, Техник, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, Салбар, нэгжийн мөнгөн хөрөнгийн үйл ажиллагааны журам батлах тухай”... зэрэг 30 орчим дүрэм, журмыг боловсруулах, хянах, баталж мөрдүүлэх зэрэг ажлыг амжилттай зохион байгуулж ажилласан байна. (<https://ncac.mn/mn/news/legalCategory/13> Жагсаалтыг хавсаргав).

Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын нэхэмжлэлтэй, Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын маргааны давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцсон.

Гурав. Монголын Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгчөөр ажиллахдаа хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээлгэх зорилгоор хууль зүйн зөвлөгөө хүссэн хувь хүмүүст үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж, 2026 онд зөрчлийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон.

Мөн анхан болон давж заалдах шатны шүүх, Дүүргийн прокурорын газар, Улсын Ерөнхий прокурорын газар, зарим төрийн байгууллагад өргөдөл гомдол гаргах, бичихэд нь хууль зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлсэн байна.

Дээрх үүрэгт ажлуудаас гадна нийгмийн хариуцлагын хүрээнд:

- 2021 оны 1 дүгээр сард Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлж буй сэтгэцийн өвчтэй хүмүүст туслах хандивын аян гэр бүл, найз нөхдийн хүрээнд санаачлан зохион байгуулж, шинэ чанартай дулаан өмд хувцас, дотуур хувцас, оймс, бусад ахуйн хэрэглээний үнэ бүхий зүйлсийг гардуулан өгсөн. Мөн тус клиникээс хүсэлт тавьсны дагуу байгууллагын зүгээс хагас автомат угаалгын машин бэлэглэж, албадан эмчлүүлэгчдийн ахуй нөхцлийг бага ч болтугай сайжруулахад анхаарч ажилласан.

- 2023 оны 6 дугаар сард ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангид ял эдэлж байгаа хоригдлуудын нярай, бага насны хүүхдүүдэд нэмэлт хоол тэжээл, живх, сандал, суудал, хувцас хатаагч, зарим нэн шаардлагатай эм бэлмдэл зэрэг эд зүйлсийг хүлээлгэн өгсөн.

Жич: Дээрх албан тушаалуудад ажиллахдаа үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр, холбоо барих мэдээлэл зэргийг хүснэгтийн 3.1-д тус тус дурдсан болно.

Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл

-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга

замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.

- 2025 онд шинээр байгуулагдсан Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс үйл ажиллагаандаа дагаж мөрдөх 30 гаруй журам, дүрмүүдийг боловсруулах, хянах, батлуулжээ. (Жагсаалтыг хавсаргав).

- “Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын стратегийн ялгаа, зохицуулалтын зөрчил” нийтлэлийг БНХАУ-ын судлаач Zhang Yulantaй хамтран бэлтгэж, БНХАУ-ын “New era of Science and technology” сэтгүүлд хэвлүүлсэн. (2024.09.17) CN:11-3750/N, ISSN:1006-981X, 82-721

- “The Some Issues of Corruption in Mongolian and Other Asian Countries Cases” өгүүлэл. *Journal of Humanities and Social Sciences, 7(6), 01-05, 2024-д нийтлэгдсэн.

- “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн ойлголтыг авч үзэх нь” өгүүлэл. *Дотоод хэргийн их сургууль. Удирдлагын академи. “Хууль сахиулахуйн удирдлага” онол арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2024., №02 (27)-д нийтлэгдсэн.

- 2021 онд “Авлигын гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шүүхээс хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага” судалгааны тайланг бэлтгэсэн.
* Нийслэлийн прокурорын газар “Авлига-урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд, судалгааны тайлан, 2021. УБ,-д нийтлэгдсэн.

- Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. “Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд” гарын авлага. 2020., УБ хот-д нийтлэгдсэн.
* Прокурорын байгууллагаас авлигын гэмт хэргийг шалган шийдвэрлэх, хяналтын үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор хуульчдад зориулсан гарын авлагыг боловсруулахад оролцсон.

- СЭЗИС-ийн оюутнуудад “Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн шинж, шүүхийн практик” сэдвээр лекц уншсан. 2022.11.16 СЭЗИС 4С.

- 2014-2023 онуудад Их, дээд сургуулийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьчилан сэргийлэх зорилгоор Мансууруулах бодис, түүний хууль бус эргэлттэй тэмцэх сэдвээр лекц уншиж, сургалт явуулж байсан.

	<p>- 2021 оны 6 дугаар сард “Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал” салбар дундын анхдугаар зөвлөгөөнд оролцон прокурорын хяналтын талаар илтгэл тавьж, тулгарч буй 3 асуудал, гарц гаргалгааны талаар санал гарган хэлэлцүүлсэн.</p> <p>- 2016 онд “Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудлууд” сэдвээр хууль зүйн магистр хамгаалсан.</p> <p>- Одоогийн байдлаар “Үндэслэлгүйгээр хөрөнгөжихийн эсрэг эрх зүйн зохицуулалт” сэдвээр диссертацийн ажил бичиж, судалгаа, шинжилгээний ажил хийж байна.</p>
4.3	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу?</p> <p>Тийм.</p> <ol style="list-style-type: none"> 2012 оны 9 дүгээр сарын 19-нөөс одоог хүртэл хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 14 дэх жилдээ эзэмшиж байна. Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч. Улсын Дээд шүүхээс 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг олгосон. 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор дахин томилогдсон тул өмгөөлөгчийн эрхийг түр түдгэлзүүлсэн байсан. 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээсэн ба одоог хүртэл 3 жил 2 сарын хугацаанд эзэмшиж байна. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч.
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> 2020-2025 онд Их Засаг их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн докторын түвшний сургалтыг төгссөн. 2025.06.16 №20250602. 2013-2016 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль. Хууль зүйн ухааны магистр. 2016.06.02 №201650000
4.5	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу? Үгүй</p>

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: ЧИМЭД

Өөрийн нэр: ОТГОНСҮРЭН

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

---oOo---